



Б И М А У
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1998 оны 3 сарын 26

№ 78

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны авто баазыг талаар авах зарим арга хэмжээний тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Авто баазын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хотын Өмчийн газар /н.Найцан/-т ДААЛГАХ нь:

а/Авто баазын хөрөнгийн чөлөө, санхүүгийн эх үүсвэрийг харгалзан газар эцэлбэрийн төлбөрөөс чөлөөлсүгэй;

б/Автомашин, тоног төхөөрөмж авах, материаллаг баазад бэхжүүлэх, үндсэн үйл ажиллагаагаа явуулах зардал нь зориулж үндсэн хөрөнгө бүрдүүлэх сангаас 1,0 сая төгрөг, "Туул-Минлан" цэцгүүрийн монголын талын оногдол ашгаас 1,0 сая төгрөгийг хотын гүйцэтгэх захиргааны авто баазад олгосугай.

3. Авто баазын захиргааны ажиллагсийн сарын цаливгийн санг тогтоож мөрдүүлэхийг Санхүүгийн газар /н.Гонгор/-т даалгасугай.

4. Норм дууссан, цаашид үйлчилгээнд явах боломжгүй зарим автомашиныг авто баазын техникийн комиссын шалган тогтоосон актыг үндэслэн улсын үйлдвэрийн газрын хуулийн дагуу худалдалах, түрээсийн үйлчилгээнд явуулах асуудлыг шийдвэрлэж байхыг Авто бааз /н.Төрбат/-д зөвшөөрсүгэй.

5. Гадаад худалдааны үйл ажиллагаа явуулах, гэрээ контракт байгуулах, гадаацаас салбэг материал авахад нь зориулан барааны зохих сан бүрдүүлж өгөхийг хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны Материал хангамжийн хэлтэс /н.Вигжидсүрэн/-т даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

[Signature]
Д.ЭНЭБИШ

[Signature]

Ц.БОЛДСАЙХАН



1992

Улаанбаатар хотын Ардын Хурлын
Гүйцэтгэх захиргааны 1992 оны
78 дугаар тогтоолоор батлав.

**УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ АВТО БААЗ
/УҮГ/-ЫН ЦҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны авто бааз нь Улаанбаатар хотын хурлын байгууллагууд болон тэр, захиргааны газар, удирцах газруудад автомашинаар үйлчлэх, үйлчилгээний ажлыг БНМАУ-ын төрийн өмчид тулгуурлан явуулах улсын үйлдвэрийн газар /УҮГ/ бөгөөд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулж удирдана.

Хоёр. I. Үйлдвэрийн газар үйл ажиллагаандаа БНМАУ-ын хууль тогтоомж, засгийн газрын болон хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны тогтоол, шийдвэр, авто баазын /УҮГ/-ын цүрэм, холбогдох эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

2. Авто бааз нь /УҮГ/ цүрэмдээ заасан үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж орлогоороо зарлагыг нөхөж, аж ахуйн бүрэн тооцооны үндсэн дээр бие дааж ажиллана.

3. Авто баазын дарга нь Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны өмнө ажлаа хариуцан тайлаглана.

БНМАУ-ын хууль тогтоомжинд нийцүүлэн тушаал, заавар гаргах, байгууллагын хүрээнд мөрдүүлнэ.

4. Байгууллагын эд хөрөнгийг БНМАУ-ын хууль тогтоомжинд заасан дагуу захиран зарцуулна.

5. Авто бааз нь 3-5 хүний бүрэлдэхүүнтэй захиргааны гишүүдтэй байна. Захиргааны гишүүц нь баазын даргад зөвлөх эрхтэй бөгөөд тэд нарыг баазын дарга тушаалаар томилно.

6. Авто баазын аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг төрийн эрх бүхий байгууллага хянаж шалгана.

7. Авто бааз нь тогтоосон журмын дагуу тэмцэг, албан бичгийн хөвлөмөл хуудас хэрэглэнэ.

8. Эрх бүхий байгууллага нь үйлдвэрийн газрын эрхийг хүндэтгэн сахих, бие даан ажиллах үйл ажиллагаанд орох болохгүй байх үүргийг хүлээнэ. Эрх бүхий байгууллага зөвхөн БНМАУ-ын хууль тогтоомж, эрх зүйн бусад актад заасан эрх хэмжээний дагуу заалт өгч байж болно.

9. БНМАУ-ын хууль тогтоомж, Засгийн газар, хотын Арми Хурлын гүйцэтгэх захиргааны тогтоол, шийдвэрийг зөрчвөл БНМАУ-ын хууль тогтоомжийн дагуу кариуцлага хүлээнэ.

Гурав. Авто баазын үүрэг, эрх:

а/Авто бааз нь цор дурсан үүрэг хүлээнэ.

1. Санхүү статистикийн асууцал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу анхны шатны болон нягтлан боцох бүртгэлийг хөтөлж, тооцоо тайлан тэнцлийг гаргах.

2. Ажиллагчдын эдийн засаг, техникийн болон эрх зүйн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, давтан бэлтгэх, гэрээ захиалгын үндсэн дээр өөрийн зарцлаар боловсон хүчин бэлтгэх арга хэмжээ авах.

3. Авто машинаар үйлчлэх төрийн байгууллагуудын үйлчилгээний ажлыг чанарын өндөр түвшинд, гомцол чирэгцэлгүйгээр явуулж байх.

б/Авто бааз нь цор дурсан эрхийг эдлэнэ.

1. Авто баазад ажиллагсдын тоо, мэргэжлийн бүрэлдэхүүнийг тогтоох, удирдлагын аппаратын цалингийн санг харьяа дээд байгууллагаараа тогтоолгосны үндсэн дээр аппаратын бүтэц, орон тоог тогтоох.

2. Улс орон нутгийн төсөвт татвар, хураамж, төлбөр төлсний дараа өөрийн мэдэлд үлцэх хөрөнгийг хөцөлмөрийн хэлс, нийгмийн хөгжлийн болон үйлдвэрлэл шинжлэх ухаан техникийг хөгжүүлэх сан болон бусад арга хэмжээнд зарцуулах.

3. Тэтгэврийн нэмэгцэл, буцалтгүй тэтгэмж олгох мөхцөл журмыг тогтоох.

4. Улсаас хагуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ тарифыг тогтоох.

5. БНМАУ-ын Засгийн газраас тогтоосон журмын дагуу үндсэн сангийн элэгцэл хорогдлын шимтгэл байгуулж зарцуулах.

6. Тогтоосон журмын дагуу гадаад худалдааны үйл ажиллагаа бие даан явуулах, бие төлөөлөгчийн хэмжээнд гэрээ контракт байгуулах.

7. Технологийн дамжлагын тоног төхөөрөмж, норм дууссан авто машиныг дээд байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр бусад худалдах шилжүүлэх данснаас хасах.

Дөрөв. Өөрчлөн байгуулах, татаж буулгах.

Улаанбаатар хотын Арми Хурлын гүйцэтгэх захиргааны авто баазыг өөрчлөн байгуулах, татаж буулгах асууцлыг Улаанбаатар хотын Арми Хурлын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.